



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 9 сарын 25 өдөр

Дугаар 400

Улаанбаатар хот

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв”  
төрийн өмчит үйлдвэрийн газрын  
зохион байгуулалтын бүтэц, албан  
тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг  
шинэчлэн батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай.

- 1.1. Захиргаа, удирдлагын хэлтэс;
- 1.2. Санхүүгийн хэлтэс;
- 1.3. Судалгаа, төсөл, хөтөлбөрийн хэлтэс;
- 1.4. Сэргээгдэх эрчим хүчний техник хяналтын хэлтэс.

2. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийн схемийг 1 дүгээр, албан тушаалын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

3. “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын орон тооны хязгаарыг 39 (гучин ес) байхаар тогтоосугай.


4. Шинээр батлагдсан ажлын байрны тодорхойлолтыг баталж, цалингийн эх үүсвэрийг батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэхийг захирал Ц.Цэрэнд даалгасугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны “Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, албан тушаалын жагсаалт, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” 109 дүгээр тогтоолын 2, 3, 4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР


Б.ГАВАА


0002217



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн  
48 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**“СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ**





**“СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ”  
 ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН  
 АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

Д/д	Албан тушаал	Орон тоо
<b>Удирдлага</b>		
1	Захирал	1
2	Ерөнхий инженер	1
3	Дотоод аудитор	1
<b>Нэг. Захиргаа, удирдлагын хэлтэс /8/</b>		
4	Хэлтсийн дарга	1
5	Ахлах мэргэжилтэн (гэрээ, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан)	1
6	Хүний нөөц, архивын мэргэжилтэн	1
7	Хуулийн мэргэжилтэн	1
8	Гадаад харилцаа, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн	1
9	Захирлын туслах, бичиг хэргийн ажилтан	1
10	Үйлчлэгч	2
<b>Хоёр. Санхүүгийн хэлтэс /7/</b>		
11	Хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч	1
12	Тооцооны нягтлан бодогч	1
13	Нярав	1
14	Худалдан авах ажиллагаа, дотоод сүлжээ хариуцсан мэргэжилтэн	1
15	Техник, аж ахуйн ажилтан	1
16	Жолооч	2
<b>Гурав. Судалгаа, төсөл, хөтөлбөрийн хэлтэс /10/</b>		
17	Хэлтсийн дарга	1
18	Ахлах инженер	1
19	Инженер эдийн засагч	1
20	Нарны эрчим хүчний инженер	1
21	Салхины эрчим хүчний инженер	1
22	Усны эрчим хүчний инженер	1
23	Газрын гүний дулааны эрчим хүч, хураагуурын инженер	1
24	Магадлагаа, нотолгооны мэргэжилтэн	1
25	Зураг төслийн инженер	1
26	Дулааны инженер	1
<b>Дөрөв. Сэргээгдэх эрчим хүчний техник хяналтын хэлтэс /11/</b>		
27	Хэлтсийн дарга	1
28	Хяналтын ахлах инженер	1
29	Усны барилга байгууламжийн ахлах инженер	1
30	Хяналтын инженер	4
31	Электроник инженер	1
32	Цахилгааны инженер	1
33	Засварын мастер	1
34	Техникч	1
<b>НИЙТ</b>		<b>39</b>